

ПАКИСТАН - АРИУН ДАГШИН ОРОН

*Л.Бэгзжав**

Өмнөд Азийн баруун хойт хэсгийн Инд мөрний сав газарт, зүүн талаараа Энэтхэг (2912 км), зүүн хойгуураа Хятад (523 км), баруун хойгуураа Афгантай (2430 км), баруугаараа Ирантай (909 км) хиллэж, өмнүүрээ Аравийн тэнгисээр хүрээлэгдэн, Саудын Арабтай далай алслан оршдог, Пакистан улсын газар зүйн байрлал стратегийн чухал ач холбогдолтой. Аравийн тэнгисийн өмнө этгээдэд Энэтхэгийн далай, баруухантай нь Персийн булан оршдоогоос хүйтэн дайны үед дэлхий нийтийн анхаарлын төв болж, АНУ-ын Өмнөд Азийн эх газар дахь стратегийн гол түнш байв.

Исламын Бүгд Найрамдах Пакистан Улс нь (The Islamic Republic of Pakistan буюу Ислами Жхумри Талая Пакистан) нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ дэлхийд 34-р байранд буюу 803940 км² газар нутагтай, хүн амын тоогоороо дэлхийд 6-рт жагсдаг буюу 172 сая 800 мянган хүн амтай.¹

Пакистаны хүн ам 1998 оны хүн амын тооллогоор 130 сая байсан бол 10 жилийн дараа 2008 онд даруй 42 сая хүнээр нэмэгджээ.² Олон үндэстний Пакистан орны угсаатны бүрэлдхүүний 63% нь пенжаб, 18% нь синдх, 11% нь пуштун, 4% нь белуж үндэстэн ажээ. Пакистаны үндэстний үзэлтээр Ислам шашин шүтдэг бүхий л хүн газар орон, арьс үндэстэн, хэл яриа, соёлын уламжлал хийгээд улс төрийн шүтлэг бишрэл ялгахгүйгээр бүгд мусулам үндэстэнд хамаарна.³ Олон жилийн турш Пакистанд албаны болон ардын дунд мусулам шашинтныг “нэг үндэстэн” буюу “олон тоот үндэстэн” гэж, мусулам бишийг нь “цөөн тоот үндэстэн” гэдэг онол үйлчилсээр иржээ.⁴ Хүн амынх нь 96% нь ислам шашин шүтдэг Пакистан улсын хэл -урду, албан ёсны хэл –англи хэл бөгөөд засаг захиргааны 4 муж нь тус бүрдээ нэг гол нутгийн аялгатай. МЭӨ III-II зуунд Пакистаны нутаг дэвсгэр дээр хүн төрлөхтөний соёл иргэншлийн өлгий нутгийн нэг Хараппын улс үүсчээ.

Хараппа дахь 4000 жилийн түүхтэй Индийн хөндийн соёл иргэншлийн олдворуудаас харахад МЭӨ I зууны үед энэ нутагт Аричүүд, Монголжуу төрхийн улсууд зэрэгцэн амьдарч байжээ.⁵ Энэ нутагт буддын шашин тархсан анхны голомтын нэг Кушаны хаант улс үүссэн ба МЭ YII зуунаас исламын шашин өргөн тархаж, дундад зууны үед хүчирхэг мусульманы улсууд оршин тогтнож байв.

XIII зууны үед Монголчууд Пакистаны Лахор, Мултан зэрэг хотуудыг байлдан эзлэж байсан Энэтхэг-Пакистан Турк султанууд, Монголчуудтай улс төрийн харилцаатай байсан тухай Пакистаны

* Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Лахор хотын Пенабийн их сургуулийн профессор доктор Иар Мухаммед Хан 1942 онд Хятадын Шэнянь хотод болсон “Азийн олон улсын эрдэм шинжилгээний хурал” дээр илтгэл тавьж байсан билээ.

1757 онд Англичууд Энэтхэг-Пакистаныг эзлэн авч 190 жил колончилсон түүх бий. 1947 онд уулаасаа нэг улс байсан Энэтхэг, Пакистан хоёр тус тусдаа өөртөө засах хараат улс болж 1947 оны 8-р сарын 14-нд Пакистан тусгаар тогтнолоо тунхагласан юм.

Пакистаны дотоод дахь үндэстний зөрчил мөргөлдөөн, тулгарч байсан эдийн засгийн ноцтой асуудал, улс төрийн тогтворгүй байдлын улмаас Энэтхэг, Пакистан, Хятад, Афганы дунд орших “Кашмирын асуудал”-аас шалтгаалан Энэтхэг, Пакистаны хооронд 3 удаа дайн болж, 1971 онд Пакистан улсын зүүн хэсэгт тусгаар тогтносон Бангладеш улс байгуулагджээ.

Пакистан гэдэг нэрийн тухайд Перс хэлнээс гаралтай “Пак” гэдэг нь цэвэр, боргожуун, ариун дагшин гэсэн утгатай стан гэдэг нь улс гэсэн үг, өөрөөр хэлбэл “цэвэр ариун хүн оршин суудаг газар” гэсэн утга илэрхийлнэ. Урду хэлээр “лалын шашинт улс” гэсэн утгатай гэдэг. Пакистаны нэрийг тус улсын 8 гол үндэстний эхний үсгийн дуудлагаас бүрдсэн гэсэн тайлбар ч байдаг. Мөн 1933 онд мусульман оюутан Чаудри Рехмат Али-гийн Пакистаны Пүсэг нь Пенжаб, А – нь Афган, К- нь Кашмир, С нь Синд, Тан гэдэг нь Белужстан гэдгээс үндэстэй гэсэн саналыг үндэслэлгүй гэж үзэх нь бий.

Пакистаныг “дорно дахины жимсний сагс” гэж өргөмжлөн нэрлэдэг.⁶ Олноос хэтийдсэн онц сайхан байгалийн нөхцөлтэй Пакистан жимс жимсгэний орон юм. Гүйлсийн мод гэхэд 60 гаруй төрөл байдаг аж. Өмнөөсөө умар тийш халуун бүс (тропик) дулаан бүс (субтропик), халуун, жихүүн уур амьсгалтай тус орны аагим халуун өмнөд нутагт манго, наргил, нимбэг, гадил, бэржгэр лууны нүд, цагаан цэцэгт анар, хан боргоцой, дулаан ба халуун бүсэд тоор, жүржлэг, жихүүн хүйтэн хойт хэсэгт гүйлс, тоор, интоор гэх мэт төрөл бүрийн жимс ургадаг.

Газар тариаланг гол болгож, гадаадын тусламжид түшиглэдэг Пакистан хөвөн тариалалтаар дэлхийн гол орны нэг ба цагаан будааг экспортлодог, байгалийн их баялагтай, дэлхийн хамгийн томд тооцогдох 430 сая тн нөөцтэй⁷ хромын (Cr) орд газартай, мөн байгалийн хий, газрын тос, зэс, хөнгөн цагаан, гантиг, эрдэнийн чулуу, ураны их нөөцтэй. Цөмийн зэвсэгтэй, сансарын хиймэл дагуул бүхий улс юм. Пакистаны анхны атомын цахилгаан станцыг 1982 онд Канадын тусламжтайгаар Карачи хотод байгуулжээ.

1947 онд тусгаар тогтнох үедээ Английн колони Энэтхэгийн зах хязгаарын хоцрогдсон газар байсан Пакистанд Энэтхэг хуваагдсаны дараа Энэтхэгийн 14677 аж үйлдвэрийн газрын 9.6%

буюу 1414 үйлдвэр, 3.1 сая ажилчдын 200 мянга нь оногдож байв.⁸ Үндэсний мөнгөн тэмдэгтгүй, авто зам, төмөр зам, телефон, телеграф шуудан холбоо үндсэндээ байхгүй, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн бааз суурьгүй, хэрэгцээт бараагаа зөвхөн Энэтхэгээс солилцон авдаг байсан Пакистан улс тусгаар тогтносон 60 гаруй жилийн түүхэндээ олон янзын бэрхшээл туулж, эвдэрч сүйрсэн эдийн засгаа сэргээх гэж уналт-хөгжилт-уналт-сэргэлтийн замаар замнаж улс ардын аж ахуйн хөгжлийн хурдаар Баруун Өмнөд Азид тэргүүлж, гуравдагч орны дотор тэргүүн эгнээнд гарч, эдийн засгийн орчин үеийн шилжилтийг даван туулж буй хөгжлийн сургамж туршлага нь сургамжтай.

Шашны уламжлалт зан заншлаа хатуу барьдаг тус орны төрийн тэргүүн нь мусулам шашин шүтдэг байх ёстой бөгөөд улс даяараа цорын ганц спиртийн үйлдвэртэй ч архи уухыг чандлан хориглодог зөрчвөл 6 сар хүртэл шоронд хоригдох ялтай.⁹ Дээд, дунд, бага сургуульд шашны хичээл заадаг. Пакистанд 1991 онд Исламын хууль баталж “Коран” судар ба лалын уламжлалт сахил санваар бол улсын хамгийн дээд хууль мөн гэдгийг зарлажээ. Гэвч шашны асуудал тус орны дотоодын олон хямралын гол шалтгаан болдог.

Пакистаны “цөөн тоот үндэстний” нэг нь Хималайн нурууны өмнөд бэлд цас мөсний дунд орших эртний гайхалтай, хаалттай, олон өнгө хосолсон цэвэр цэмцгэр Бардистан гэдэг газар үеэс үед оршин суусаар ирсэн уулын иргэд юм. Тэд төвдүүдтэй соёл, үндэстний хувьд мянган утас түмэн шижмээр холбогдсон бөгөөд суугуул нутгаа “жигжигхэн Төвд” хэмээдэг. Бардистан хүмүүсийн хэл нь Төвд хэлний баруун хэсгийн салбар бөгөөд өнөө ч тэндэхийн хүн амын хэл ярианы 50-иас дээшхи хувийг төвд үгсийн сан эзэлдэг аж.¹⁰ Бардистан хүн гадаад төрхөөрөө төвдүүдтэй төстэй төдийгүй, төвд хүний адил замбаа гурил (арвайн гурил) идэх дуртай, алсаас ирсэн гийчнээ сүүтэй цайгаар дайлдаг, настайчуул нь өнөө ч гэсэн төвд үндэстний “Гэсэр хаан”-ы туулийг хайлдаг гэнэ.

Улсынхаа албан ёсны нэрийг хэдэнтээ солисон Пакистан улстай манай улс 1962 оны 7-р сарын 6-нд дипломат харилцаа тогтоосон ч хүйтэн дайны нөхцөлд, Пакистаны цэрэг улс төрийн бодлого, үзэл суртал, бусад хүчин зүйлсийн улмаас өнөөг хүртэл ёс төдий харилцаатай байна. Шинэ цаг үед Баруун Өмнөд Азийн нөлөө бүхий Пакистантай тогтоосон дипломат харилцаагаа сэргээн хөгжүүлэх асуудлыг хөндөж үзэх шаардлага манай гадаад бодлогод гарахыг үгүйсгэх аргагүй.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. <http://ru.wikipedia.org/wiki/Пакистан>
2. 王臣家, 新版各国概况《亚洲》, 北京市, 2002年, 第51页
Ван Чэнжя “Шинээр хэвлэгдсэн олон орны байдал (Ази)”
Бээжин., 2002 он. 51-р тал
3. Ислам, мусулам шашинтаныг лалын шашинтан гэдэг боловч,
тухайн нутгийн ойлголтоор өөр өөр ойлголт ажээ.
4. 王鸣野, 美国的欧亚战略与中南亚五国, 新疆人民出版社, 乌鲁木齐, 2003年, 第152页
Ван Мин Е “АНУ-ын Европ Азийн стратеги ба Төв ба Өмнөд
Азийн 5 орон” Шинжааны ардын хэвлэлийн хороо. Өрөмч.,
2003 он. 152-р тал
5. Монприйт Вохра. Энэтхэг- Монголын харилцаа: өнгөрсөн,
одоо, ирээдүй. India Тусгаар тогтнолын 50 жил УБ. 1997,
67-р тал
6. 张忠祥, 世界各国国名集锦, 世界知识出版社, 北京 1987年, 第9页
Жан Жунсян “Дэлхийн олон орны улсын нэрийн хураангуй”
“Дэлхийн мэдлэг” хэвлэлийн хороо, Бээжин., 1987 он. 9-р тал
7. 与增河, 中国周边国家概况北京市, 1994年, 第399页
Ю Зэнхө “Хятадын хөрш орнуудын байдал” Хятадын
үндэстний их сургуулийн хэвлэлийн хороо, Бээжин., 1994
он. 399-р тал
8. 孙培钧, 刘创源, 南亚国家发展战略研究, 北京大学出版社, 北京市, 1992年, 第18页
Сун Пэйюе, Лю Чуанюань “Өмнөд Азийн улсуудын эдийн
засгийн хөгжлийн стратегийн судалгаа” Бээжин Их
сургуулийн хэвлэлийн хороо, Бээжин., 1992 он. 18-р тал.
9. “Өнөөдөр” сонин. 2008.1.18. №4
10. Хятадын “Хуанчю шибao” сонин (“Ертөнцийн цаг”)
2005.11.14. №1048